



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/05

Онги

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Төгрөг багийн нутаг "Гүн худгийн бууц" /45<sup>0</sup>,45.16.35N/, "Төгрөгийн хонхор" гэх газруудад 2024 оны 01 сарын 14-15-ны өдөр малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсон тул хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосон өвчний голомттой бүс нутгаас мал шилжүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглосугай.

3. Голомтын бүс нутгийн мал сүрэгт эмнэлзүйн үзлэг, ариутгал халдваргүйтгэл, эмчилгээ хийж ажиллахыг "Энх мэнд сүрэг" мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн малын эмч (Э.Энхсайхан) мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч эмч (Г.Дэлгэрмаа) нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ард иргэд, малчдыг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хорио цээрийн дэглэмийг журмын дагуу явуулж, пост ажиллуулж, хяналт тавьж нийгмийн хэв журмыг сахиулан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга



(С.Болоржаргал), хэсгийн төлөөлөгч (Ш.Ууганбаяр), багийн Засаг дарга  
(Х.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Ц.АЛТАНГЭРЭЛ

СОНОСХ АЖИЛТЭГЭН ТЭВГЭЭН 2024

ШУИЦАХ СУРГУУЛЬ

ЗАСАГ ДАРГА

Хүндэтгэсэн

Хүндэтгэн

Хүндэтгэн

